



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/360

Ховд

“Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг
буулган дахин шинээр барих тухай

“Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай” Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин шинээр барих үйл ажиллагааны журмын дагуу Жаргалант сумын Жаргалан багийн нутаг дэвсгэрт орших ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн багш нарын 455м² талбайтай байрыг буулган дахин барих ажлыг зохион байгуулсугай.

2. Шинээр барих барилгын санхүүгийн эх үүсвэрийг хууль журмын дагуу төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх, түр суурьшуулах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Ц.Ганданповрон/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/, аймгийн Орон нутгийн өмчийн газар /Ш.Нохойжав/, аймгийн Ерөнхий архитектор /З.Өмиртай/ нарт үүрэг болгосугай.

3. Төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх, түр суурьшуулах ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 01794
D/Zax-A/360-Da